


БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэл

АУДИТЫН КОД: БУА-2023/51-04-ШТА-НА



Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ

Утас: 70342850 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn

Аудитын менежер Ж.Энхцоодол

Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор Г.Цэрэнлхам

Утас: 70342716 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хаяг:
www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Булган аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ Аудитын менежер Ж.Энхцоодол Аудитор Г.Цэрэнлхам Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70342716 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон, 403 тоот 2023 оны 6 дугаар сар	Товчилсон үгс	3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
	Дүрслэлийн товьёг	6
	Хүснэгтийн товьёг	6
	<u>Бүлэг 1.</u>	
	Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан төлөвлөгөөний дагуу сонгуулийн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.	7-8
	<u>Бүлэг 2.</u>	
	Булган аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулсан байна.	9-10
	<u>Дүгнэлт</u>	
	Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуваарилж, батлагдсан төсвийг СЕХ-ны ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу зарцуулж, 610.7 мянган төгрөгийг хэмнэж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.	11
	Тайлан баталгаажуулсан тушаал	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
СХ	Сонгуулийн хороо
МТБ	Мэдээлэл технологийн баг

График товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн сонгуулийн хорооны батлагдсан төсөв	7
Дүрслэл 2	Аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл	9

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах аймгийн СХ-ны батлагдсан төсөв	7
Хүснэгт 2	Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах сумын СХ-ны батлагдсан төсөв	8
Хүснэгт 3	Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах аймгийн СХ-ны зардлын гүйцэтгэл	10

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөө, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дах хэсэгт зааснаар “Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Булган аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргаж, аймгийн Сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ❖ Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан төлөвлөгөөний дагуу төсвийг төлөвлөж, хуваарилсан эсэх
- ❖ Булган аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг үр ашигтай, зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Сонгуулийн тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”
- ✓ Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулна.

**Аудитын үндсэн
мэдээлэл:**

Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг Булган аймагт зохион байгуулахад аймгийн сонгуулийн хорооны гишүүн 6, сумдын сонгуулийн хорооны гишүүд 5, хэсгийн хорооны гишүүд 9, бусад 5 ажилтан нийт 25 ажилтан албан хаагч томилогдож, Улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн даамал, онцгой байдлын газрын ажилтан, цагдаа, эрүүл мэндийн ажилтан, нутгийн захиргааны байгууллагын ажилтан хамтран ажилласан байна.

Хангал сонгогчийн нэрсийн жагсаалтад бичигдсэн 422 сонгогчийн 57.8 хувь буюу 244 сонгогч сонгууль өгсөн байна.

Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад урьдчилсан судалгааг хийж нөхцөл байдлыг тодорхойлон Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос аймаг, нийслэлийн сонгуулийн хороодод хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналд хийх аудитын эрсдэлийн үнэлгээг “ДУНД” гэж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-1, 6817-5, 6817-7, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан шалгадагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, Аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэлээ.

БҮЛЭГ-1

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан төлөвлөгөөний дагуу сонгуулийн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.



Сонгуулийн ерөнхий хороон нь СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасны дагуу төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумдын сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан Булган аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн хороонд СЕХ-ны Ажлын албаны даргын 2023 оны А/19 дүгээр тушаалаар 25,413.2 мянган төгрөгийг хуваарилсан байна.

Дүрслэл-1



Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан

Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахад аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв
1	Маягт хэвлүүлэх зардал	100.0
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	50.0
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	240.0
4	МТБ, даамлын сургалтын зардал	20.0
5	Бичиг хэргийн зардал	550.0
6	Шуудан холбооны зардал	600.0
7	Унааны зардал	1,470.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	300.0
9	Сурталчилгааны зардал	500.0
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	3,594.0
11	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МТБ-ийн зардал	170.0

12	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	120.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн дүн мэдээ дамжуулах/	105.0
14	Томилолтын зардал	1,774.0
15	Болзошгүй зардал	500.0
16	Саналын хуудас устгах зардал	320.2
17	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	13,200.0
18	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	1,800.0
НИЙТ ДҮН		25,413.2

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан

Аймаг, сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахад аймгийн Сонгуулийн хороонд 6 гишүүн, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан тус бүр 1, сумын СХ-нд 5 гишүүн, хэсгийн хороонд 9 гишүүн, аймаг, сумын мэдээлэл технологийн багт 3, нийт 25 ажилтан томилогдож, сонгуулийн хорооны гишүүдийн урамшууллын зардалд 51.9 хувь буюу 13,200.0 мянган төгрөг батлагдаж, бүрэн зарцуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо 13,066.2 мянган төгрөг буюу 51.4 хувь, Хангал сумын сонгуулийн хороо 12,347.0 мянган төгрөг буюу 48.6 хувийн төсөв зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт-2

Д/д	Зардлын нэр	Төсөв /мян.төг/
1	Сонгуулийн хорооны сургалтын зардал	140.0
2	МТБ, даамлын сургалтын зардал	20.0
3	Бичиг хэргийн зардал	250.0
4	Шуудан холбооны зардал	300.0
5	Унааны зардал	945.0
6	Санал авах байр бэлтгэх	300.0
7	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	336.0
8	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МТБ-ийн зардал	-
9	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	120.0
10	Томилолтын зардал	336.0
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	8,400.0
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	1,200.0
ДҮН		12,347.0

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан

СХХ-оос баталсан төсвийн хуваарийн дагуу орж ирсэн санхүүжилтийг цаг хугацаанд нь аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод олгосон байна.

БҮЛЭГ-2

Булган аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулсан байна.



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 сарын 19-ний өдрийн А/17 тоот захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3.2¹, 3.3² дахь заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

Булган аймгийн сонгуулийн хорооны төсвийг нийт 25,413.2 мянган төгрөг хуваарилагдсанаас аймаг, сумын сонгуулийн хорооны зардалд 24,802.5 мянган төгрөгийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, 610.7 мянган төгрөгийн хэмнэж ажилласан байна. Төсвийн хэмнэлтийг СЕХ-ны төрийн сангийн 100900022001 тоот дансанд 2023 оны 06 сарын 21-ны өдөр буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл-2

/мянган төгрөг/



Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан

Аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 95.3 буюу 12,455.5 мянган төгрөгийг зарцуулж, 4.7 хувь буюу 610.7 мянган төгрөгийн төсвийг хэмнэж ажилласан

¹ “Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна”

² “Аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны нягтлан бодогчоор дараах шаардлага хангасан хүнийг ажиллуулна.....”

байна. Харин Хангал сумын сонгуулийн хороо 12,347.0 мянган төгрөгийн төсвийг бүрэн зарцуулсан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хорооны батлагдсан төсвийн гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт 3

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	хэтрэлт, хэмнэлт
1	Маягт хэвлүүлэх зардал	100.0	100.0	-
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	50.0	50.0	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	240.0	240.0	-
4	МТБ, даамлын сургалтын зардал	20.0	20.0	-
5	Бичиг хэргийн зардал	550.0	547.5	2.5
6	Шуудан холбооны зардал	600.0	600.0	-
7	Унааны зардал	1,470.0	1,470.0	-
8	Санал авах байр бэлтгэх зардал	300.0	300.0	-
9	Сурталчилгааны зардал	500.0	500.0	-
10	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	3,594.0	3,594.0	-
11	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МТБ-ийн зардал	170.0	170.0	-
12	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	120.0	120.0	-
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн дүн мэдээ дамжуулах/	105.0	-	105.0
14	Томилолтын зардал	1,774.0	1,774.0	-
15	Болзошгүй зардал	500.0	-	500.0
16	Саналын хуудас устгах зардал	320.2	317.0	3.2
17	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	13,200.0	13,200.0	-
18	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	1,800.0	1,800.0	-
НИЙТ ДҮН		25,413.2	24,802.5	610.7

Эх сурвалж: Сумын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан

Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлаас бичиг хэргийн зардлыг 0.5 хувь, туршилтын болон санал авах өдрийн дүн мэдээ дамжуулах унааны зардал, болзошгүй зардал 100 хувь, саналын хуудас устгах зардлыг 0.9 хувиар тус тус хэмнэж ажилласан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуваарилж, батлагдсан төсвийг СЕХ-ны ажлын албанаас өгсөн чиглэлийн дагуу зарцуулж, 610.7 мянган төгрөгийг хэмнэж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 4/12

Булган сум

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангал сумын ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн зардлын гүйцэтгэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын ажлын баримтыг үдэж, цэгцлэн архивын нэгж болгож ажиллахыг аудитор (Г.Цэрэнлхам)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

006010035